



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 9/129

Мандалговь

Гэр бүлийн хөгжлийг дэмжих аймгийн
дэд хөтөлбөр"-ийг боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын а, д, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19.1.1, 19.1.4, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчинг дэмжих, гэр бүл дэх хүүхэд хамгааллыг сайжруулах зорилгоор "Гэр бүлийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр"-ийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч:	А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)
Гишүүд:	Б.Түвшинбаяр (Хууль, эрхзүйн хэлтсийн дарга)
	О.Амарсанаа (Цагдаагийн газрын дарга)
	Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл урлагийн газрын дарга)
	Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
	Г.Бат-Орших (Эрүүл мэндийн газрын дарга)
	Ж.Өлзийжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
	Б.Оюунчимэг (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Г.Хишигдаваа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
	Б.Пүрэвжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр"-ийг боловсруулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, санал санаачлага гарган ажиллахыг нийгмийн бодлогын хэлтэс, ажлын хэсгийн ахлагч (А.Нарантуяа), гишүүдэд үүрэг болгосугай.

488191214

Гурав. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр"-ийг боловсруулан, зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс, ажлын хэсгийн ахлагч (А.Нарантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ